

Санхүүжилтийн хөнгөлөлттэй нөхцөлүүд (хөнгөлөлттэй зээл)

Экспортын баталгаа ба хөнгөлөлттэй зээл
2019 оны 8-р сарын 14-ний өдрийн байдлаар

Индекс

-
- 1. Хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх (хөнгөлөлттэй зээл) - Оршил**
 - 2. Хөнгөлөлттэй зээл авах эрхтэй хүлээн авагч орнууд**
 - 2.1 Одоогийн байдлаар хөнгөлөлттэй зээл авах боломжтой орнууд**
 - 3. Хөнгөлөлттэй зээл авах боломжтой бүтээгдэхүүн / төсөл**
 - 3.1. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын зохицуулалт**
 - 3.2. Австрийн хөнгөлөлттэй зээлийн бодлого**
 - 3.2.1 Үйлчилгээ**
 - 3.2.2 Зах зээлд нэвтрэх**
 - 3.2.3 Эдийн засгийн бодлогын хамаарал**
 - 3.2.4 Төслийн тогтвортой байдал**
 - 4. Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл**
 - 5. Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн өргөдөл гаргах журам**
 - 5.1 Сонгон шалгаруулалтын аргаар гэрээ байгуулах**
 - 5.2 Шууд хэлэлцээр хийх замаар гэрээ байгуулах**
 - 6. Төслийг тодорхойлох / эсвэл бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Холбооны Сангийн яамны хөтөлбөр**

Хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх (хөнгөлөлттэй зээл) - Оршил

Экспортын санхүүжилтийг арилжааны нөхцөлөөр хангахаас гадна Австрийн экспортлогч үйлдвэр нь тодорхой нөхцөлд хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилтийг ашиглаж болно (1-6 дугаар бүлгийг үзнэ үү). Хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилтийг зөвхөн тодорхой төсөлд хамрагдсан орнуудад олгох боломжтой.

Хөнгөлөлттэй зээлийн бодлого

Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нь Холбооны Сангийн яамны хөнгөлөлттэй зээлийн бодлогын дагуу хүлээн авагч орнуудын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн зорилго бүхий, олон улсын зах зээл дээр өрсөлдөж буй Австрийн экспортлогчдод зориулагдсан. Санхүүжилтийг зөвхөн европогоор хийнэ.

Экспортлогчдод тавигдах шаардлага

Австри улсад оршдог экспортын компаниуд /өрөнхий гүйцэтгэгчид нь холбогдох салбар дахь холбогдох техникийн ноу-хау бүхий ажилтнуудыг ажиллуулах ёстой бөгөөд тэдгээр нь цаашид мэдлэгээ хөгжүүлэхэд бэлтгэгдсэн байна. Цаашилбал экспортлогч/өрөнхий гүйцэтгэгч нь тэдгээр холбогдох ажилтнуудтай урьд нь холбогдох салбарт хөнгөлөлттэй бус нөхцөлтэйгээр төсөл хэрэгжүүлж байсан болон цаашид үргэлжлүүлэн ажиллах талаар тайлан гаргаж өгөх ёстой.

Хөнгөлөлттэй зээлийн төрөл

Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг урьдчилсан холимог хэлбэрээр (энэ нь бага хүүтэй, үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа бүхий урт хугацааны зээлийн нөхцөлтэй зээл юм) эсвэл холимог зээл хэлбэрээр (Холбооны Сангийн яамнаас олгодог буцалтгүй тусlamж болон хөнгөлөлттэй зээлээс бүрдэх санхүүжилтийн багц) олгох боломжтой. Эдгээр тааламжтай нөхцөлийг Австрийн төрийн байгууллагуудын албан ёсны дэмжлэгээр боломжтой болгосон.

Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт нь хөгжлийн тодорхой бодлогыг дэмжихтэй холбоотой тул Холбооны Сангийн яам батлан даалтын төлбөрийг бууруулах тусгай арга хэмжээг санхүүжилтийн бусад зардлын хэсэгчилсэн төсөөлөлтэй хослуулан санал болгож, хүлээн авагч орны зардлыг бууруулж байна.

Австри улсын ашиг сонирхол

Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг тусlamжийн зээл хэлбэрээр өгдөг бөгөөд голчлон Австри улсын гаралтай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортоор хязгаарлагддаг. Гадаад талын зөвшөөрөгдөх хамгийн дээд хэмжээ нь (гуравдагч орны гадаад контент, дотоодын зардал гэх мэт) нь гэрээний үнийн дүнгийн 50 хувиар хязгаарлагддаг.

Үнэлгээ

Төслүүдийг үнэлэх ажлыг Австрийн Контрол Банкны Олон улсын харилцаа ба шинжилгээ/ Улс орнуудын дүн шинжилгээ ба олон улсын харилцаа хариуцдаг алба хариуцдаг. Үүний тулд экспортлогч нь экспортын баталгааны тухай өргөдөлд нэмж оруулах ёстой маягтыг бөглөдөг.

“Де минимис” гэж нэрлэгдэх төслүүд буюу гэрээний үнэ цэнэ нь 2 сая ЗТЭ (Зээлжих тусгай эрх)–ээс доош төслүүдийн хувьд хялбаршуулсан санал асуулга явуулахаар төлөвлөсөн болно. Энэ нь төсөл болон экспортлогч компанийн тухай мөн төслийн онцлогтой холбоотой асуултуудыг агуулдаг.

Тиймээс, Австрийн экспортлогч компаниуд өргөдөл гаргасан төслөө хэрэгжүүлэхийн тулд холбогдох ноу-хау байгаа эсэхээ нотолж чадсан тохиолдолд л Австрийн хөнгөлөлттэй зээлээс ашиг хүртэх боломжтой. Мөн асуулгад Австрийн хөнгөлөлттэй зээлийн бодлогын дагуу цэвэр/давамгайлсан үйлчилгээний хувьд хөнгөлөлттэй зээл авах боломжтой үйлчилгээний талаар нарийвчилсан тодорхойлолтыг оруулсан болно.

Австрийн экспортлогчдод тавих зээлийн үнэлгээ, гүйцэтгэлийн эрсдэлийн шаардлагуудаас гадна өргөдөл гаргах журмын хүрээнд тус экспортлогчийн арилжааны нөхцөлөөр санхүүжсэн бизнес болон хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр санхүүжсэн бизнесийн хоорондох харьцааг илүү нарийвчилж үздэг.

2. Хөнгөлөлттэй зээл авах эрхтэй хүлээн авагч орнууд

Эдгээр орнууд нь:

- ЭЗХАХБ-ын зохицуулалтын дагуу нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүн нь өнөөгийн байдлаарх хязгаар болох 3,995 ам.доллараас бага;
- Австрийн хамгаалах бодлогын дагуу дунд болон урт хугацаанд хамтран ажиллах;
- Австрийн хөнгөлөлттэй зээлийн бодлогод хөнгөлөлттэй зээл олгохоор тодорхой тусгасан зорилтот орнууд юм.

Боломжит хязгаарлалтууд

Шаардлагатай тохиолдолд хөнгөлөлттэй зээл авах эрх бүхий бүлгийн зарим улс орнуудад болон гүйлгээнд хязгаарлалт тавигдаж болно. Хүлээн авагч улс эдийн засаг, улс төрийн сөрөг нөлөөнд өртсөн тохиолдолд ийм арга хэмжээ авах шаардлагатай байж болзошгүй. Австрийн хамгаалах бодлогод хамрагдахгүй улсуудад хөнгөлөлттэй зээл олгогдохгүй.

2.1 Одоогийн байдлаар хөнгөлөлттэй зээл авах боломжтой орнууд

ЭЗХАХБ-ын зохицуулалт ба Холбооны Сангийн яамны хөнгөлөлттэй зээлийн бодлогын дагуу дараах улсууд хөнгөлөлттэй зээл авах боломжтой байна.

Хаалтанд байгаа хэсгээс ЭЗХАХБ-ын орнуудын эрсдэлийн ангилал (3-7 дугаар ангилал), НҮБ-ын ХБХО (Хамгийн бага хөгжингүй орнууд)-ын ангилал болон ОУВС (Олон улсын валютын сан) ба Дэлхийн банк (ДБ)-ны хөнгөлөлтийн хамгийн бага шаардлагыг харж болно.

Хүлээн авагч орон бүрийн гүйлгээний жишигийг Австрийн Контрол Банкны Экспортын баталгаа ба хөнгөлөлттэй зээлийн асуудал хариуцсан багийн утсаар авах боломжтой.

Бүх хүлээн авагч оронтой холбоотой ямарваа өөрчлөлт гарч болзошгүй тул Австрийн Контрол Банкны Экспортын баталгаа ба хөнгөлөлттэй зээлийн багтай бизнес хөгжил/гэрээ хэлэлцээрийн үе шат бүрт холбоо барина уу.

ЭЗХАХБ-ын зохицуулалт ба Холбооны Сангийн яамны хөнгөлөлттэй зээлийн бодлогын дагуу дараах улсууд хөнгөлөлттэй зээл авах боломжтой байна.

2019 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар:

Бүс	Орнууд
Баруун Балкан	Косово (ангилал 7)
Хар тэнгисийн бүс	Гурж (ангилал 6), Молдав (ангилал 7, ОУВС)
АзИ	Бангладеш (ангилал 5, ХБХО), Энэтхэг (ангилал 3), Индонез (ангилал 3), Монгол (ангилал 6), Мьянмар (ангилал 6, ХБХО), Филиппин (ангилал 3), Шри Ланк (ангилал 6), Вьетнам (ангилал 4)
Төв болон Өмнөд Америк	Болив (ангилал 5), Эл Сальвадор (ангилал 5), Гондурас (ангилал 5)
Сахарын цөлөөс урагш орнууд	Ангол (ангилал 6, ХБХО), Камерун (ангилал 6, ОУВС/ДБ), Этиоп (ангилал 7, ХБХО, ДБ), Кени (ангилал 6, ОУВС), Лесото (ангилал 6, ХБХО), Руанда (ангилал 6, ХБХО, ОУВС/ДБ), Сенегал (ангилал 5, ХБХО, ОУВС/ДБ), Танзани (ангилал 6, ХБХО, ОУВС/ДБ), Уганда (ангилал 6, ХБХО, ОУВС/ДБ), Замби (ангилал 7, ХБХО);
Ойрхи Дорнод / Хойд Африк / Африкийн бусад улсууд	Кабо Верде (ангилал 6), Египт (ангилал 5), Морокко (ангилал 3), Тунис (ангилал 5)

3. Хөнгөлөлттэй зээл авах боломжтой бүтээгдэхүүн / төсөл

3.1. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын зохицуулалт

- Төслийн үйл ажиллагааны болон ажиллах хүчний зардлыг нөхөх бэлэн мөнгөний урсгалыг зах зээлийн зарчмаар бий болгох боломжгүй төслүүд (Санхүүгийн чадавхи болон Анхны тулхүүр тест)

Эсвэл

- Зах зээл дээр санхүүжилт авах боломжгүй эсвэл бусад ЭЗХАХБ-ын орнуудаас санхүүжүүлэх төсөл (Санхүүгийн бэлэн байдал болон Хоёр дахь тулхүүр тест).

Бүтээгдэхүүн/төсөл нь хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн шаардлагад нийцэж байгаа эсэх талаар мэдээлэл авах зорилгоор ЭЗХАХБ-ын "Хөнгөлөлт, тусlamжийн талаарх удирдамж"-ийг ашиглах боломжтой. Энэхүү удирдамж нь 1992 оноос хойших бүтээгдэхүүн/төслүүдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн сонголтын талаарх туршлагын эмхтгэл юм.

3.2 Австрийн хөнгөлөлттэй зээлийн бодлогын дагуу

3.2.1 Үйлчилгээ

Цэвэр/давамгайлсан үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжүүлэх тохиолдолд үнэлгээнд тусгай шалгуурыг ашиглана. Үйлчилгээ нь тухайн зорилгод нийцсэн, тодорхой байх ёстой бөгөөд ажил дууссаны дараа шууд үр нөлөө нь хэрэгжилтийн дараа шууд дуусахгүй, удаан хугацаанд хадгалагдаж үлдэхээр байна. Үйлчилгээ нь бусад бүх үйлчилгээнээс хараат бус байх ёстой бөгөөд энэхүү үйлчилгээг дагасан боломжит хөнгөлөлттэй зээлийн төслийн бэлтгэл арга хэмжээ байх ёсгүй.

3.2.2 Зах зээлд нэвтрэх

Хөнгөлөлттэй зээл нь ойрын ирээдүйд хөнгөлөлттэй зээлийн төслүүдийг хэрэгжүүлснээр цаашид арилжааны нөхцөлөөр санхүүжүүлэх боломж гарч ирнэ

гэсэн хүлээлт бүхий шинэ зах зээлд гарах "үүд хаалга" болох ёстой. Хөнгөлөлттэй зээлийг тасралтгүй олгох ёсгүй.

Энэхүү шалгуурт зориулан Австрийн экспортлогчид шинэ зах зээлийг хэрхэн нээж байгаа талаарх мэдээллийг тодорхой цаг хугацааны төлөвлөлттэй гаргаж өгөх ёстой. Энэ нь зөвхөн гэрээний өртөг нь 2 сая ЗТЭ-ээс дээш төслүүдэд шаардагдана.

3.2.3 Эдийн засгийн бодлогын хувьд хамаарал (технологийн үр нөлөөг мөн хамааруулна)

Энэ нөхцөлд бүтээгдэхүүн/үйлчилгээ эсвэл экспортын пүүс / үйлдвэрлэгчийн Австрийн эдийн засгийн бусад салбарт үзүүлэх нөлөөллийг судалж үздэг. Энэхүү судалгааны үр дүн хөнгөлөлттэй зээлийн өргөдлийн ерөнхий үнэлгээнд багтсан болно.

Эрүүл мэндийн төслүүдийн хувьд Австрийн талаас дараах лавлагаа шаардлагатай.Үүнд:

- Австрийн бодит нэмүү өртөгт онцгой анхаарал хандуулна,
- Бие даасан тесөлд Австрийн гарал үүсэлтэй бус тоног төхөөрөмж Австрийн талын нийлүүлэх хэсгийн үнийн дүнгээс хэтрэхгүй байх ёстой бөгөөд үүнийг гарал үүслийн гэрчилгээг үндэслэн тодорхойлно,
- Суурь эрүүл мэндийн төслүүдийн хувьд зөвхөн тоног төхөөрөмж нийлүүлэхийг эсвэл олон байршилд төслийг хэрэгжүүлэхийг дэмжихгүй.

Гэрээний үнэ 2 сая ЗТЭ-ээс доош байгаа төслийн хувьд хялбаршуулсан журмыг хэрэглэнэ.

3.2.4 Төслийн тогтвортой байдал

Австрийн хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөс ашиг хүртэх төслүүд нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж, улмаар хүлээн авагч орны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах ёстой. Тиймээс тогтвортой хөгжлийн онцлогтой холбоотой зүйлийг бүтээгдэхүүн/төслийн үнэлгээнд тусгасан болно.

Төслийн тогтвортой байдлын үнэлгээг төслийг хэрэгжүүлсний дараа хийдэг.

Гэрээний үнэ 2 сая ЗТЭ-ээс доош байгаа төслийн хувьд эцсийн тайлан шаардагдана. Гэрээний үнэ 2 сая ЗТЭ-ээс дээш төслүүдэд хяналтын журам шаардлагатай. Хяналт хийх цар хүрээг төсөл тус бүрээр тус тусад нь тогтоодог.

Гэрээний үнэ 2 сая ЗТЭ-ээс доош/дээш үнэ бүхий төслүүдийн ялгааг асуулгаас харж болно.

4. Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл

ЭЗХАХБ-ын зохицуулалтын дагуу хөнгөлөлттэй зээлийн доод хэмжээ нь 35% байх шаардлагатай. НҮБ-ын ангилал (ХБХО улсууд) -ын дагуу "Хамгийн бага хөгжилтэй орнуудад" олгох хөнгөлөлттэй зээл нь дор хаяж 50% -ийн хөнгөлөлттэй байх ёстой.

"Тогтвортой зээлийн санхүүжилтийн санаачилга" -д хамрагдах хөнгөлөлттэй зээл авах боломжтой орнуудын тухайд нь Олон улсын валютын сан (ОУВС) -гийн шаардлагад нийцсэн байх ёстой.

Дээр дурьдсан хөнгөлөлтийн түвшинд хүрэхийн тулд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг урьдчилсан холимог зээлийн хэлбэрээр (энэ нь бага хүйтэй, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа бүхий урт хугацааны зээлийн нөхцөлтэй зээл) эсвэл холимог зээлийн хэлбэрээр (ихэвчлэн Холбооны Сангийн яамнаас олгодог

буцалтгүй буцалтгүй тусламж болон хөнгөлөлттэй зээлээс бүрдэх санхүүжилтийн багц) тооцогддог.

Төрийн захиргааны байгууллагаас олгосон хөнгөлөлтийн ерөнхий түвшин нь хүүгийн татаас болон бусад өртгийн бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ (баталгааны төлбөр болон бусад санхүүжилтийн зардлыг бууруулах)

Ердийн урьдчилан холимог хөнгөлөлттэй зээлийн хугацаа нь 16-26,5 жил, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 5-12 жил, жилийн 0 хувийн хүүтэй байдаг.

Ердийн холимог хөнгөлөлттэй зээлийн хугацаа нь 19,5-27,5 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 6-9,5 жилийн хугацаатай, жилийн 0 хувийн хүүтэй байдаг. Холимог зээлийн 10-15 хувиас доошгүй хэсэг нь буцалтгүй тусламжаас бүрдэнэ.

5. Хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн өргөдөл гаргах журам

5.1 Сонгон шалгаруулалтын аргаар гэрээ байгуулах

Австрийн экспортлогч тендерт оролцоо төлөвлөж байгаа бол тухайн тендерийн хугацаа дуусахаас 40-өөс доошгүй хоногийн өмнө бидэнд мэдэгдэх ёстой. Тендерийн хугацаа ажлын 40 хоногоос богино байх тохиолдолд экспортлогч тендерийн ажлын эхний 5 хоногийн дотор өөрийн оролцооны талаар бидэнд мэдэгдэх ёстой.

Энэ зорилгоор маягтыг бөглөж, дээр дурдсан хугацаанд Австрийн Контрол Банкны Экспортын баталгаа ба хөнгөлөлттэй зээлийн баг руу илгээх ёстой. Үүнтэй хамт "Zustimmungserklärung zur Notifikation" (мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл) -ийг Экспортын баталгаа ба хөнгөлөлттэй зээлийн багт илгээнэ. Зохих баталгаа, санхүүжилтийн өргөдлийг тендер шалгаруулалтын дараа нэн даруй ирүүлэх ёстой. Австрийн холбогдох хороодоос гаргасан шийдвэрийг нийтэд дэлгэхээс өмнө нийлүүлэх гэрээнд гарын үсэг зурах ёсгүй.

Энэхүү өргөдлийн журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авах боломжгүй болно.

5.2 Шууд хэлэлцээр хийх замаар гэрээ байгуулах

Шууд хэлэлцээ хийх тохиолдолд холбогдох баталгаа, санхүүжилтийн өргөдлийг нийлүүлэлт хийх гэрээний хэлэлцээрийн эхэнд ирүүлэх ёстой. Австрийн холбогдох хорооноос гаргасан шийдвэрийг нийтэд мэдээлэхээс өмнө буюу хүчин төгөлдөр байгаа ЭЗХАХБ-ын мэдэгдлийг авахаас өмнө нийлүүлэлт хийх гэрээнд гарын үсэг зурах ёсгүй.

Энэхүү өргөдлийн журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт авах боломжгүй болно.

6. Төслийг тодорхойлох эсвэл бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Холбооны Сангийн яамны хөтөлбөр (товчоор "Хөнгөлөлттэй зээлийн төсөл бэлтгэх хөтөлбөр")

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл авах боломж бүхий экспортлох үйл ажиллагаатай холбогдуулан төсөл тодорхойлох эсвэл төсөл бэлтгэх арга хэмжээг Холбооны Сангийн яамны буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх боломжтой. Энэхүү хөтөлбөр нь ерөнхийдөө ЭЗХАХБ/Хөгжлийн туслалцааны

хорооны жагсаалтын дагуу тусlamжийн санхүүжилт авах шаардлагатай хөгжиж буй орнуудад хамаарна. Түүгээр ч бараахгүй тус төслүүдийг Австрийн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх бодит боломж байх ёстой.

Австрийн Контрол Банк

1011 Вена, Штрахгассе 3

Утас. +43 1 531 27-1718

softloans@oekb.at

www.oekb.at